Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХЯНАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ, ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Тө-сөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | |
| Зорилт 1.1. Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.-зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.1.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналт хийсэн өгөгдлийн санд дүн шинжилгээ хийж, үр дүнд тулгуурласан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br><br>*БГТ- 1.1.3* | - | Дүн шинжилгээ хийсэн өгөгдлийн тоо Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон бусад холбогдох тоон мэдээллийг нийт 140 удаа бэлтгэж холбогдох арга хэмжээ авсан. | Нэхэмжлэлийн хяналтын үр дүнд цаашид шаардлагатай арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | Нэхэмжлэлийн хяналтын 2024, 2025 оны өгөгдлийн санд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллээр тухай бүр ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон бусад холбогдох тоон мэдээллийг нийт 68 удаа бэлтгэж, холбогдох газар, хэлтсүүд, удирдлагуудад хүргүүлсэн байна. | 100% |
| Зорилт 1.2. "Цахим шилжилтэд бүрэн шилжинэ."-зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.2.1 | Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ.<br><br>*МУТЖҮЧ-2.2.5, ЗГҮАХ-2.3.2.7, БГТ-ий 1.2.5* | - | Цахимд нэвтрүүлсэн шалгуурын тоо | ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 тогтоолын хүрээнд нийт 30000 мөр шалгуурыг мэдээллийн санд оруулж холбосон. | Шинээр батлагдсан чанар, төлбөрийн хяналтын шалгуурыг цахим системд оруулна. | - ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нэхэмжлэлийн хяналтын шалгуурыг шинээр болон шинэчлэн боловсруулах зорилгоор Мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулан, гэрээний дагуу 1400 онош, үйлдлийн хүрээнд нэхэмжлэлийн хяналтын шалгуурыг боловсруулж ЗЕХ-ийн дагуу тогтоолын төслийг нийтдээ 4 удаа, 30 хоног emd.gov.mn сайтад байршуулан санал авсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2025.04.04-ний өдөр ЭМДЕГ-ын emd.gov.mn сайтын “цахим хэлэлцүүлэг” хэсэгт байршуулан санал авсан.<br>- ЭМДҮЗ-ийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоол шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор ОХБ-н дугаарыг нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгууртай холбож цахим системд оруулсан.<br>- Дээрх тогтоолоор яаралтай тусламж, үйлчилгээний шинэ эрэмбэ батлагдсантай холбоотойгоор эрэмбийн дагуу шинэчилсэн шалгуурыг боловсруулж, цахим системд холбосон. | 70% |
| 1.2.2 | Хяналтын самбарын хөгжүүлэлт, ашиглалтыг нэмэгдүүлж, дашбордыг хөгжүүлнэ.<br><br>*БГТ-ий 1.2.4, МУТЖҮЧ-2.2.5* | - | Програм хангамжид шинээр хөгжүүлсэн модулийн тоо | Хяналтын самбар 23 | Хяналтын самбарын мэдээллийн төрлийг нэмсэн байна. | Яаралтай тусламж, үйлчилгээг 72 цаг дотор давтан авсан, 30 хоногийн дотор давтан хэвтэн эмчлүүлсэн, даатгуулагчийн мэдээллийг харах “tableau” системийн хяналтын 5 самбарыг хөгжүүлэн цахимд байршуулсан. | 100% |
| 1.2.3 | Tableau системээс судалгаа, боловсруулалт хийж холбогдох газар, хэлтэст мэдээллийг хүргүүлнэ. | - | Мэдээлэл хүргүүлсэн тоо | Нэхэмжлэлийн хяналтын үр дүн, тоон мэдээллийг тухай бүр бэлтгэн холбогдох газарт хүргүүлсэн. | Дүн шинжилгээ, судалгааг хийж, холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн, танилцуулсан байна. | - Tableau системээр холбогдох судалгаа мэдээллийг бэлтгэж өдөр бүр танилцах боломжтой болгон хөгжүүлэлтийг хийж байна.<br>- Мөн 2025 оны 01-02 дугаар сарын нэхэмжлэлийн хяналтаар илэрсэн зөрчил, гүйцэтгэл нь өмнөх сарын мөнгөн дүн, тоо хэмжээнээс 20-оос дээш хувиар хэтэрсэн ЭМБ-уудын мэдээллийг ХАГГ-т гарган хүргүүлсэн. | 100% |
| 1.2.4 | ЭМД-ын HICS цахим системийг шинээр хөгжүүлэх, сайжруулах, засварлах бодлогын даалгаврыг тухай бүр боловсруулж МТХ-д хүргүүлж нэвтрүүлнэ. | - | Хүргүүлсэн бодлогын даалгаврын тоо<br><br>Хэрэгжилтийн хувь | ЭМД-ын цахим системд оруулсан ажлын даалгаврын тоо-28 | МТХ-т бодлогын даалгаврыг хүргүүлж, цахим системд оруулан | - ЭМДҮЗ-ийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” тогтоол шинэчлэн батлагдсантай холбоотой нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуурын ОХБ-н дугаарыг холбох бодлогын даалгаврыг МТХ-т бэлтгэн хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ашигласан байна. | - HICS системийн цахим хяналтаар хасагдсан гүйцэтгэлийг зөрчил тус бүрээр бүлэглэн харах бодлогын даалгаврыг хүргүүлсэн байна. | |
| Зорилт 1.3. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.-зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1.3.1 | Салбарын холбогдох хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд холбогдох хууль тогтоомжтой уялдуулан санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ.<br><br>*БГТ-ий 1.3.2* | - | Хүргүүлсэн саналын тоо | ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын төсөл дээр ажилласан. ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоол, Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний журмын төсөл, ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолд санал боловсруулж БТГ-т хүргүүлсэн. | Холбогдох хууль, дүрэм, журам, тогтоолын төслүүдэд санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. | *<u>Санал өгсөн талаар:</u>*<br>Байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги боловсруулах ажлын хүрээнд эрсдэлийн судалгаанд 2 санал өгсөн.<br>*<u>Санал авсан талаар:</u>*<br>- ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан "Нэхэмжлэлийг хянах журам"-ыг шинэчлэн батлуулахаар ЭМДЕГ-ын газар, хэлтсүүдээс санал авч, ирүүлсэн саналыг нэгтгэн тусгасан.<br>- ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Чанар төлбөрийн хяналтын журам"-ын төсөл болон нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуур, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх ТҮ, анхан шатны 4 төрлийн ТҮ-ий шалгуурын төслийг ЭМДЕГ-ын цахим хуудас (emd.gov.mn)-д ЗЕХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу 25.04.04-ний өдрөөс олон нийтэд нээлттэйгээр байршуулан санал авсан. | 100% |
| 1.3.2 | Нэхэмжлэлийн хяналтын шалгуурын тайлбар, аргачлалыг боловсруулан ЭМДЕГ-ын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаан ажиллана. | - | Шинэчлэн батлагдсан шалгуурын тайлбар, аргачлал | ЭМДЕГ-ын даргын 2023 оны А/35 дугаар тушаалаар 3896 дэлгэрэнгүй шалгуурын тайлбар, аргачлалыг батлуулж, цахим системд холбосон. | Шинээр батлагдсан шалгуур бүрд тайлбар, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | - Хугацаа болоогүй | - |
| Зорилт 1.4.Хөндлөнгийн хяналтад тулгуурласан хамтын ажиллагааг бэхжүүлнэ.-зорилтын хүрээнд: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1 | ЭМДТХ-ийн 14.8.5, 23.3 дахь заалтын хүрээнд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн шинжээч ажиллуулна.<br><br>*БГТ-ий 1.4.2* | - | Шинжээч эмчийн тоо<br><br>Шинжээчийн дүгнэлтээр илэрсэн зөрчил | Нэхэмжлэлийн болон нэмэлт хяналтад давхардсан тоогоор 109 шинжээч эмч ажилласан. | Шаардлагатай тохиолдолд нэхэмжлэлийн хяналт болон нэмэлт хяналтад шинжээч эмч нарыг гэрээгээр ажиллуулна. | <u>Шинжээч эмч нэмэлт хяналт хийсэн талаар:</u><br>2025 оны хагас жилийн байдлаар ЭМДЕГ-ын даргын 2025.01.30-ны өдрийн А/14, 2025.04.09-ний өдрийн А/43, 2025.05.06-ны өдрийн А/59 дүгээр тушаалуудаар нийт 3 удаагийн нэмэлт хяналтыг зохион байгуулан ажиллаж байна. Давхардсан тоогоор нийт 11 ЭМБ-ын эм, мэс засал, хөнгөвчлөх, УАУ-ны тусламж, үйлчилгээний 1343 түүвэрт, 6 шинжээч эмч, НХХ-ийн 1 мэргэжилтэн хяналтыг хийж гүйцэтгэж байна. Одоогоор 3 ЭМБ-аас 47,929,732 төгрөгийн авлага, 7 ЭМБ-д 159,085,264 төгрөгийн өглөг олгохоор тооцсон байна.<br><br><u>Шинжээч эмч нэхэмжлэлийн хяналт хийсэн талаар:</u><br>ЭМДЕГ-ын даргын 2025.02.12-ны өдрийн “Нэхэмжлэлийн хяналт хийх тухай” А/21 тоот тушаалаар хэвтүүлэн эмчлэх эм, мэс засал, уламжлалт анагаах ухааны ТҮ-ийн нийт 14 тохиолдлын 4170 түүвэрт давхардсан тоогоор 12 шинжээч эмч нэхэмжлэлийн хяналт хийсэн. | 100% |
| 1.4.2 | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтаар илэрсэн ноцтой зөрчлийг бүртгэж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | - | Зөрчлийн тоо<br><br>Зөрчил бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Завших оролдлого 257,<br>хуурамч нэхэмжлэл 114,<br>код ахиулсан 4857 тохиолдол | Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтаар илэрсэн ноцтой зөрчлийг бүртгэж, ХАГГ-тай хамтран холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | - Тайлант хугацааны 2025 оны 01, 02 дугаар сарын нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтаар илэрсэн ноцтой зөрчлийг тусламж, үйлчилгээний төрлөөр гарган, 11888 мөр бүхий даатгуулагчийн мэдээллийг ХАГГ-т ДАБ-аар хүргүүлсэн.<br>- Ноцтой зөрчил бүртгэгдсэн ЭМБ-уудын 02 дугаар сард үзүүлсэн ТҮ-ийн тоо, мөнгөн дүнг 01 дүгээр сартай харьцуулан өссөн тоо, хэмжээг хүргүүлсэн. | 100% |
| Зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна-зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 3.2.1 | "Нэхэмжлэлийг хянах журам"-ыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.<br><br>*БГТ-ий 3.2.1* | - | Шинэчлэн батлагдсан журам | ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/139 дүгээр тушаал хэрэгжсэн. | Журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэн ажиллана. | ЭМДЕГ-ын даргын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/30 дугаар тушаалаар "Нэхэмжлэлийг хянах журам"-ыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:<br>- ТГ-ын 2025.01.17-ны өдрийн 04/111 тоот дотоод албан бичгээр ЭМДЕГ-ын газар, хэлтсүүдээс санал авч боломжтой саналыг тусгасан.<br>- ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан журмын 18 зүйл заалтад өөрчлөлт оруулж, 4 заалтыг хасаж, 1 заалтыг шинээр нэмсэн.<br>- Журмын танилцуулга, нөлөөллийн шинжилгээг хийж ХЗЯ-нд хүргүүлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7161 дугаарт захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлсэн. | 100% |
| 3.2.2 | Чанар, төлбөрийн хяналтын журмыг шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.<br><br>*БГТ-ий 3.2.3* | - | Шинэчлэн батлагдсан журам | ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолыг мөрдөж байна. | Журмыг шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн тогтоолоор батлуулж хэрэгжүүлсэн байна. | - 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр *(ЭМД-ын гэрээ бүхий лавлагаа шатлалын 312, УСЭИТҮ үзүүлж буй гэрээт 112 ЭМБ, анхан шатны 552 ЭМБ8 нийт давхардсан тоогоор 976 ЭМБ)* ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Чанар төлбөрийн хяналтын журам"-ын төслийг танилцуулах танхимын болон цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, ирүүлсэн саналыг төсөлд тусгасан.<br>- Мөн тогтоолын төслийг 2025.04.04-ний өдөр ЭМДЕГ-ын emd.gov.mn сайтын "цахим хэлэлцүүлэг" хэсэгт байршуулан санал авсан. | 70% |
| 3.2.3 | Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | - | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн ЭМБ, ЭМДХ-ийн тоо | 2024 онд 244 ЭМБ-д зөвлөгөө мэдээлэл өгч, зөвлөн туслах | Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. | Нэхэмжлэлийн хяналтын шалгуур, эх олонлогийн тооцоололтой холбоотой давхардсан тоогоор 30 гаруй эрүүл мэндийн байгууллага, ЭМДХ-үүдэд биечлэн болон утсаар зөвлөгөө өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | *БГТ-ий 3.2.5* | | | үйлчилгээ үзүүлсэн. | | Тухайлбал: Бриллиант эмнэлэг, УНТЭ, УГТЭ, УХТЭ, Амгалан амаржих газар, Сэргээн засах клиник эмнэлэг, Төмөр замын НЭ, Мөнгөн морьт эмнэлэг, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, Сондра, Хасуманал, Рехамед, Сендурамед, Увс, Дархан-Уул, Завхан, Ховд аймгийн ЭМДХ-ийн мэргэжилтнүүд; | |
| 3.2.5 | Анхан шатны ЭМБ-аас үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуур боловсруулж, боловсруулж, мөрдөн ажиллана.<br><br>*БГТ-ий 3.2.8* | - | Батлагдсан шалгуур | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж үйлчилгээний 19 шалгуурын төслийг боловсруулсан. | Шалгуурыг батлуулж, батлагдсан шалгуурын дагуу нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. | - Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний нийт 19 шалгуурын төслийг шинэчлэн боловсруулж, ЗЕХ-ийн дагуу ЭМДЕГ-ын emd.gov.mn цахим хуудаст 2024.06.27, 2024.11.11, 2025.04.04-ний өдрүүдэд нийт 3 удаа байршуулан санал авсан.<br>- Мөн "Анхан шатны тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хяналтын шалгуур"-ын төслийг танилцуулах хэлэлцүүлгийн удирдамжийг батлуулж, удирдамжийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өрх, сум, тосгоны нийт 552 ЭМБ-уудыг оролцуулсан танхимын болон цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, ирүүлсэн саналыг шалгуурын төсөлд тусгасан. | 70% |
| 3.2.6 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн нарийвчилсан шалгуурыг боловсруулж, мөрдөн ажиллана.<br><br>*БГТ-ий 3.2.9* | - | Батлагдсан шалгуур | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээний 6 шалгуурын төслийг боловсруулсан. | Шалгуурыг батлуулж, батлагдсан шалгуурын дагуу нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. | - Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тусламж, үйлчилгээний 6 насны ангилал (насны ангиллаар 0-5, 6-17, 18-30, 31-45, 46-60, 61-ээс дээш)-аар шалгуурыг шинэчлэн боловсруулж, ЗЕХ-ийн дагуу ЭМДЕГ-ын emd.gov.mn цахим хуудаст 2024.06.27, 2024.11.11, 2025.04.04-ний өдөр нийт 3 удаа, 1 сарын хугацаанд байршуулан санал авсан.<br>- Мөн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр УСЭИТҮ үзүүлж буй гэрээ бүхий 112 ЭМБ-уудыг оролцуулсан танхимын болон цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирүүлсэн саналыг шалгуурын төсөлд тусгасан. | |
| 3.2.7 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зөвлөмж боловсруулж, гэрээ бүхий лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлнэ. | - | Зөвлөмжийн тоо | 2024 онд УБ-ын зөвлөмжийг 2 удаа өгсөн. Нийслэлийн лавлагаа шатлалын 195, орон нутгийн 76 ЭМБ-д зөвлөмж хүргүүлсэн. | Хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд тусламж, үйлчилгээний чанар сайжирна. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны 07-12 дугаар сард иргэн (даатгуулагч)-д үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хийсэн нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын үр дүнд нийтлэг илэрч байгаа зөрчлүүдийг үндэслэн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг ЭМД-ын гэрээ бүхий нийслэлийн лавлагаа шатлалын нийт 52 ЭМБ-уудад хүргүүлсэн. | 100% |
| 3.2.8 | ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоол өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тогтоолд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг цахим системд хийнэ. | | Холбосон шалгуурын тоо<br><br>Өөрчлөгдсөн ОХБ-ийн тохируулга | Тогтоол шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нэхэмжлэлийн хяналтын шалгуурт өөрчлөлтийг хийж, цахим системд холбосон. | Тогтоолд нийцүүлэн нэхэмжлэлийн хяналтын шалгуурт өөрчлөлт хийж, шалгуураар хянах нөхцөл бүрдсэн байна. | - ЭМДҮЗ-ийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоол батлагдсантай холбоотойгоор нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуурын ОХБ-н дугаарыг холбож цахим системд оруулсан.<br>- Дээрх тогтоолоор яаралтай тусламжийн шинэ эрэмбэ батлагдсантай холбоотойгоор эрэмбийн дагуу шинэчилсэн шалгуурыг боловсруулж, цахим системд холбосон.<br>- Мөн тогтоолын өөрчлөлттэй холбоотой холбогдох өөрчлөлтүүдийг тухай бүр хийж байна. | 100% |
| Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана. | | | | | | | |
| Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө. | | | | | | | |
| 4.1.1 | Шинээр болон шинэчлэн батлагдсан нэхэмжлэлийн чанар, төлбөрийн хяналтын шалгуурын сургалтыг төв, орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | Нэхэмжлэлийн хяналтын шалгуууртай холбоотой сургалтыг Төв орон нутгийн мэргэжилтнүүдэд 2 удаа хийсэн. | Төв, орон нутгийн нэгжийн холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. | Орон нутгийн ЭМДХ-ийн мэргэжилтнүүдэд "Цахим системд шинээр оруулсан хөгжүүлэлтийг хэрхэн хэрэглэх" талаарх сургалтыг зохион байгуулсан. (оролцогчдын тоо-59)<br>(Нэхэмжлэлийн хяналтын шалгуурыг шинээр батлагдсаны дараа холбогдох сургалтыг хийнэ) | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | “Нэхэмжлэлийн хяналтын шалгуурын аргачлал, тайлбар”-ын талаар сургалт зохион байгуулна. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолын нэхэмжлэлийн хяналтын шалгуурын сургалтыг 2 удаа хийсэн. | Төв, орон нутгийн нэгжийн холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний түүвэрлэгдсэн тохиолдлуудыг нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуураар хянахад мэргэжилтнүүдийн зүгээс гаргаж байгаа алдаа зөрчлүүдэд үндэслэн хяналтыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг 2025.04.03-ны өдрийн 08/530 тоот ДАБ-ээр орон нутгийн ЭМДХ-ийн мэргэжилтнүүдэд хүргүүлсэн. | 70% |
| 4.1.3 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг шуурхай шийдвэрлэнэ.<br><br>*БГТ-ий 4.1.11* | - | Шийдвэрлэлтийн хувь | 2024 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол 3-ыг шийдвэрлэсэн. Ирсэн албан бичиг-203, явуулсан албан бичиг-233 | Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | ***<u>Өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаар:</u>***<br>Тус хэлтсийн хэмжээнд 2025 оны байдлаар ЭМДЕГ-ын шинжээч эмч Т.Наранзулаас Болормэлмий эмнэлгийн нэмэлт хяналттай холбоотой өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн.<br>***<u>Албан бичгийн шийдвэрлэлтийн талаар:</u>***<br>1. Ирсэн дотоод албан бичиг - 41<br>Явуулсан дотоод албан бичиг - 19<br>2. Гаднаас ирсэн албан бичиг - 40<br>Гадны байгууллагад хүргүүлсэн албан бичиг - 38 | 100% |
| 4.1.4 | Нэгжийн дотоод ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллана. | - | Батлагдсан хуваарь | 2024 онд нэгжийн дотоод ажил үүргийн хуваарийг батлуулж, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. | Дотоод ажил үүргийн хуваарийг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлсэн байна. | Дотоод ажил үүргийн хуваарийн дагуу 8 ажил үүргийг 3 мэргэжилтэнд хариуцуулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:<br>- Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж ТҮЧТХГ-ын даргаар батлуулан I улирлын биелэлтийг тайлагнаж ажилласан.<br>- Долоо хоног бүрийн пүрэв гаригт ТҮЧТХГ-ын 7 хоногийн ажлын явц, үр дүнг нэгтгэн тайлан бичиж, ppt бэлдсэн.<br>- Сургалт, хэлэлцүүлгийн үед техникийн болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зэргээр төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.5 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллаж, сургалтад хамрагдан, ХАСХОМ-ыг хугацаанд нь тайлагнана. | - | Сургалтад хамрагдсан тоо<br><br>ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нь тайлагнасан байдал | Сургалтын тоо-1 Хэрэгжилтийн хувь-100% | Сургалтад хамрагдсан, ХАСХОМ-ыг хугацаанд нь тайлагнасан байна. | - Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- Хэлтсийн мэргэжилтнүүд 2024 оны ХАСХОМ, ХАСУМ-ийг шинэчлэн гаргаж, хуулийн хугацаанд эрх бүхий албан тушаалтанд үнэн зөв мэдүүлэн хүргүүлсэн. | 100% |
| 4.1.6 | Хүний нөөцийг чадавхжуулах, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Нэгж (НХХ, ХЗЧҮХ)-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаандаа батлуулсан эсэх, ГТ-ий биелэлтийг хугацаандаа тайлагнасан эсэх, хурлын тэмдэглэл | Төлөвлөгөө -1 Бичмэл тайлан-4, гүйцэтгэлийн тайлан-2 Хэрэгжилтийн хувь-100% | Төлөвлөгөө батлагдсан, тайланг хугацаанд нь тайлагнасан байна. | - ТҮЧТХГ-ын 2025 оны төлөвлөгөөний төслийг бэлтгэн газрын даргад хүргүүлсэн.<br>- ХЗЧҮХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, I улирлын бичмэл тайланг бичиж, хугацаанд нь тайлагнасан.<br>- Хэлтсийн мэргэжилтнүүдийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг бичсэн. | 100% |
| 4.1.7 | Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна. | - | ЭМДЕГ-ын албан ёсны цахим хаягаар мэдээлсэн мэдээ мэдээллийг танилсан, түгээсэн тоо | Шинжээч эмчийг сонгон шалгаруулах зар-2 удаа, цахим хэлэлцүүлэгт мэдээлэл байршуулсан тоо-3, мэдээ мэдээллийг түгээсэн тохиолдлын тоо-36 | ЭМДЕГ-ын албан ёсны цахим хаягаар зар хүргэгдсэн, мэдээ мэдээллийг таниулсан, түгээсэн байна. | - Эрүүл мэндийн даатгалын холбогдолтой шинээр батлагдан гарсан тогтоол, шийдвэр, байгууллагын үйл ажиллагааг иргэд даатгуулагчдад таниулан сурталчлах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдлэг олгох ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт хариулт зэрэг байгууллагын нүүр хуудаст тавигдсан мэдээллүүдийг бусадтай хуваалцаж, иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.<br>- Нэхэмжлэлийн хяналтын шалгуурын талаарх зөвлөгөөг орон нутгийн ЭМДХ-ийн болон НХХ-ийн мэргэжилтнүүд, шинжээч эмч нарт өгсөн.<br>- ЭМДЕГ-ын фэйсбүүк хуудсанд "Нэхэмжлэлийн хяналтыг хэрхэн хийдэг вэ" сэдвээр мэдээлэл бэлтгэн оруулсан. | 100% |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг, даалгавар | Өгсөн субъект | Биелэлт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Шүүх хуралд оролцсон тухай | ЭМДЕГ-ын дарга | ЭМД-ын гэрээ бүхий "Болор-мэлмий" эмнэлэгтэй холбоотой Захиргааны хэргийн анхан шатны 2 шүүх хуралд 1 мэргэжилтэн, ЭМДЕГ-ын гэрээ бүхий 1 шинжээч эмч ЭМДЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж байна. | 100% |
| 2 | Ажлын хэсэгт ажилласан тухай | ЭМЯ-ны сайд,<br><br>ЭМДЕГ-ын дарга | Хэлтсийн мэргэжилтнүүд нь:<br>1. ЭМДЕГ-ын даргын 2025.02.27-ны өдрийн А/32 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай"<br>2. ЭМС-ын 2025.03.31-ний өдрийн А/102 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай"<br>3. ЭМДЕГ-ын даргын 2025.04.22-ны өдрийн А/51 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай"<br>4. ЭМДЕГ-ын даргын 2025.04.28-ны өдрийн А/53 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай"<br>5. ЭМС-ын 2025.05.13-ны өдрийн А/194 тоот "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалуудаар нийт 5 ажлын хэсэгт ажиллаж байна. | 100% |
| 3 | Орон нутагт томилолтоор ажилласан талаар | Төрийн албаны зөвлөл | ТАЗ-ийн даргын 2025.01.17-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, зөвлөн туслах, төрийн албан хаагчдад ТА-ны шинэтгэлийн үйл явц, "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн шинэ хөгжүүлэлтүүд, түүнийг хэрхэн ашиглах, Ёс зүйн дэд хороо хэрхэн ажиллах талаар заавар зөвлөгөө өгөх, сумдад ажиллаж буй албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, судалгаа авах зорилго бүхий ажлын хэсэгт хэлтсийн 1 мэргэжилтэн ажилласан. Үүнд:<br>- Нийт 1246 төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл хүргэж, 1611 албан хаагчдаас ТАЗ-өөс бэлтгэсэн судалгааг авч нэгтгэн, нэгдсэн тайланд оруулахаар хүргүүлсэн.<br>- Орон нутгийн ЗДТГ, ИТХ, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Сумын ЭМТ зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлт, томилгоо, "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системийн ашиглалт, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулалтад хяналт шалгалт хийн, зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласан.<br>- Хяналт шалгалт хийсэн байгууллагуудад илэрсэн зөрчил, албан хаагчдаас ирүүлсэн санал, хүсэлтийг нэгтгэн нэгтгэл тайланд оруулахаар хүргүүлсэн. | 100% |
| 3 | Түүвэрлэлтийн талаар | ЭМДЕГ-ын дарга | - Тайлангийн хугацаанд хянах хүч, хяналт хийх өдрийн тооцооллыг бэлтгэн гаргаж, МТХ-т хүргүүлэн, 250 мянган тохиолдлыг түүвэрлэсэн байна.<br>- Түүвэрт хамаарах мэргэжилтнүүдийн мэдээллийг HICS цахим системд цаашид нэгжийн дарга нар оруулах, баталгаажуулах хөгжүүлэлтийг хийхээр МТХ-тэй хамтран ажиллаж байна. | 100% |
| 4 | Tableau системд оруулах | ЭМЯ-ны сайд, | - ЭМС-ын 2025.05.13-ны өдрийн А/194 тоот ажлын хэсэгт ажиллаж, хорт хавдрын өвчлөлийг харах хяналтын самбарыг бэлтгэсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | мэдээлэлд өргөтгөл хийсэн талаар | ЭМДЕГ-ын дарга | - Хяналтын самбарын мэдээллийг өргөжүүлэх, нэмэгдүүлэх зорилгоор МТХ-тэй хамтран HICS систем дэх дата мэдээллийг tableau баазад холбох ажлыг өргөжүүлэн хийж байна. | |

## ГУРАВ. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | **Арга хэмжээ 1.**<br><br>Мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэгүүдтэй шалгуурын төсөл дээр хамтран ажиллана. | Мэргэжлийн нийгэмлэгүүдийн боловсруулсан шалгуур дээр нь хамтран ажиллах, энэ чиглэлээр нийслэл орон нутгийн мэргэжилтнүүд, ЭМБ-уудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байх | 5 | Эх барих эмэгтэйчүүдийн нийгэмлэгтэй шалгуурын төсөл дээр хамтран ажилласан байна. | Эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр боловсруулсан 147 шалгуурын төсөл дээр Эх барих эмэгтэйчүүдийн нийгэмлэгтэй хамтран ажилласан. Жирэмслэлт төрөлттэй холбоотой шалгуурын төслийг засварласан. | 2025 оны 01-12 сар | 100% |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

**_Нэгжийн дарга_**

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

................................../Г.АРИУНСАЙХАН/

............................. *(огноо)*

*Тайлагнасан:*

**_Нэгжийн дарга_**

ХЯНАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ, ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.................................... /А.УДВАЛЦЭЦЭГ/

............................... *(огноо)*